



**“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК**  
**Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,**  
**Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,**  
**Утас/факс: 7555-0011**  
**Вэбсайт: [www.dmp.mn](http://www.dmp.mn)**

## **ХАМТРАН АЖИЛЛАХ УРИЛГА**

**2026.03.23**

Дархан-Уул аймгийн Прокурорын газрын Прокурорын 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01 дугаартай “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай” мэдэгдлийг хэрэгжүүлэх зорилгоор сургалтын үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдтэй хамтран ажиллах нээлттэй урилгыг хүргүүлж байна.

### **1. Сонгон шалгаруулалт**

- 1.1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь урилгын дагуу санал хүлээн авах сүүлийн өдрөөс 5 (тав)-аас доошгүй хоногийн өмнө хамтран ажиллах тухай урилгыг компанийн албан ёсны [www.dmp.mn](http://www.dmp.mn) цахим хуудсаар зарлан мэдээлнэ.
- 1.2. Хамтран ажиллах санал ирүүлэх хуулийн этгээд /цаашид “оролцогч” гэх/-ийг бүртгэх ажиллагаа нь урилгыг нийтэд зарласан өдрөөс эхэлж, гэрээ байгуулах эрх олгохоос 2 (хоёр) хоногийн өмнө дууссан байна.
- 1.3. Оролцогч нь сургалтын үйл ажиллагаа эрхлэгч байх бөгөөд хамтран ажиллах саналаа “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн албан ёсны [info@dmp.mn](mailto:info@dmp.mn) цахим шууданд албан бичгээр ирүүлнэ.
- 1.4. Шаардлагатай тохиолдолд оролцогчийн бүрдүүлсэн баримт бичгийн үнэн зөв эсэхийг шалгах зорилгоор холбогдох байгууллага, албан тушаалтнаас тодруулна.

### **2. Ерөнхий шаардлага**

- 2.1. Сургалтын үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээд байх, зохих туршлагатай байх, НӨАТ төлөгч байх;
- 2.2. Өөрийн сургалтын танилцуулах материал, сургалтын хөтөлбөртэй байх;
- 2.3. Сургагч багшийн хоол, буудлыг бүрэн хариуцах;

### **3. Сургалтын агуулга**

- 3.1. Хууль тогтоомжийн талаар /нийт 8 цагаас багагүй хугацааны сургалт байх/
  - 3.1.1. Авлигын тухай хууль
  - 3.1.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
  - 3.1.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- 3.2. Худалдан авах ажиллагааны талаар /нийт 16 цагаас багагүй хугацааны сургалт байх/

### **4. Гэрээ байгуулах.**

- 4.1 Оролцогчийн ирүүлсэн шаардлага хангасан үнийн саналыг бага үнийн аргаар харьцуулж “Сургалтын гэрээ”-г байгуулж хамтран ажиллана.

**Санал хүлээн авах сүүлийн хугацаа:**  
**2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл**  
**[Санал хүлээж авахтай холбоотой тодруулгыг](mailto:info@dmp.mn)**  
**[доорх цахим хаягт ирүүлнэ үү](mailto:info@dmp.mn)**  
**[info@dmp.mn](mailto:info@dmp.mn)**